



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 4/01

Баянтал сум

“Онход Лүн цацал” ХХКомпаний “Аривжих”
дэлгүүрийн тамхи худалдаалах тусгай
зөвшөөрлийг сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Лүн багийн нутагт худалдаа эрхлэгч “Онход Лүн цацал” ХХКомпаний “Аривжих” дэлгүүрт тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай сунгасугай

2.Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг сунгах тэмдэгтийн хураамж болох 250000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг Төрийн сан банкин дахь 100220400941 тоот дансанд тушаах, зөвшөөрөгдсөн цэгт тамхи худалдан борлуулахыг “Онход Лүн цацал” ХХК-ийн захирал (Ё.Нансалмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 4/02

Баянтал сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.7, 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.1, 18.4, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журмын 5.1.4, 5.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянтал сумын 2-р багийн 16-р оорцог зөрлөгт нутаглаж буюу малчин Л.Түвшинжаргалын суурьт 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр сумын малчин Б.Батзолбоо сууриас 2 үхэр, 2 тугал нийт 4 толгой малыг 5938250 дугаартай мал эмнэлгийн гэрчилгээтэйгээр шилжилт хөдөлгөөн хийгдсэн байх тул 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хүртэл хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Хязгаарлалт тогтоож, малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гаргах, оруулах зэргийг хориглож 2 дугаар багийн Засаг дарга (Т.Ган-эрдэнэ) нарт даалгасугай.

3.Хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэр дэх малд үзлэг хийх, хашаа хорооны ариутгал халдваргүйтгэл хийхийг "Чойр таван эрдэнэ" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Ж.Баярчимэг)-д үүрэг болгосугай.

4.Хязгаарлалтын дэглэм тогтоосон газар, бэлчээрийн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэд хязгаарлалтын дэглэмийг мөрдөх, захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Т.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

4212500002

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР
ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМ ТОГТООХ
ТУХАЙ САНАЛ

2025.01.20

Баянтал сум

Баянтал сумын 2-р багийн 16-р оорцог зөрлөгт нутаглаж буюу малчин Л.Түвшинжаргалын суурьт 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр сумын малчин Б.Батзолбоо сууриас 2 үхэр, 2 тугал нийт 4 толгой үхэр 5938250 дугаартай мал эмнэлгийн гэрчилгээтэйгээр ирсэн тул Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.1, 18.4, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журмын 5.1.4, 5.1.7 дахь заалт, Төв аймгийн Батсүмбэр сумын эрсдэлтэй бүс нутгаас амьд малын шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа тул 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоох саналыг хүргүүлж байна.

Иймд холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын засаг даргын захирамж гаргаж хязгаарлалтын дэглэм тогтоож хяналт тавьж хамтран ажиллана уу.

САНАЛ БИЧСЭН:

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  /О.ДӨЛГӨӨН/



МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ

МЭГ дугаар: Meg5938250

Гэрчилгээ гаргасан: Чандмань-Оточ

Баталсан: Төв, Батсүмбэр сумын МЭТ

Зориулалт: Үржил

Хүчинтэй хугацаа: 2025/01/18 - 2025/01/25

Хийгдсэн шинжилгээ: Эрүүл мэндийн үзлэг

Үүсгэсэн огноо: 2025-01-18 09:53

Баталсан огноо: 2025-01-18 17:03

Малын мэдээлэл

№	Төрөл	Нас	Хүйс	Тоо
1	Үхэр	3+нас	Эр	1
2	Үхэр	3+нас	Эм	3

Хаанаас:

Нэр: БАТЗОЛБОО.Б

Хаяг: Төв, Батсүмбэр, 3-р баг, Баянгол

Утас: 89801125

Хаашаа:

Нэр: ТҮВШИНЖАРГАЛ.Л

Хаяг: Говьсүмбэр, Баянтал, 2-р баг

Утас: 86069330

Хариуцагчийн мэдээлэл:

Нэр: Нямдорж.Т

Утас: 99701550

Тээврийн хэрэгсэл: 3630УКА

Тайлбар:

4тооны үхэр 2 үнээ, 2тугал



Санамж: Энэхүү МЭГ нь амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг өвчингүй бүс нутгаас гаралтай, шаардлагатай вакцинд хамрагдсан, тухайн үед эрүүл байгаа, хүнсэнд хэрэглэх бол эмийн үлдэгдэлгүй гэдгийг баталгаажуулна. Лавлагаа мэдээллийг МЭГ-ын мэдээллийн нэгдсэн сан www.vet.certificate.mn сайтаас шууд авах боломжтой. Ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд 51261601 дугаараар холбогдон тайлбар мэдээлэл авч болно.

Эцэг/эхийн нэр: БАТ-АМГАЛАН
Нэр: БАТЗОЛБОО
Хаяг: Төв , Батсүмбэр , 3-р баг, Баянгол
Утас: 89801125

Төлөвлөгөөт ажлын мэдээлэл

#	Малын төрөл	МЭҮ	Гүйцэтгэсэн	Малын тоо	Мал эмнэлэгийн нэгж
1	Үхэр	Бусад-Угаалга	2024/08/15 - 2024/08/15	35	Чандмань-Оточ
2	Үхэр	Бусад-Туулгалт	2024/06/13 - 2024/06/13	35	Чандмань-Оточ
3	Нохой	Бусад-Туулгалт	2024/10/31 - 2024/10/31	1	Чандмань-Оточ
4	Үхэр	Үхрийн арьс гууртах -Боловсруулалт	2024/04/23 - 2024/04/23	35	Чандмань-Оточ
5	Үхэр	Бусад-Боловсруулалт	2024/05/15 - 2024/05/15	35	Чандмань-Оточ
6	Үхэр	Шүлхий-Вакцин	2024/06/03 - 2024/06/03	36	Чандмань-Оточ
7	Адуу	Адууны томуу -Үзлэг хийх	2024/10/17 - 2024/10/17	11	Чандмань-Оточ
8	Үхэр	Шүлхий-Үзлэг хийх	2024/10/09 - 2024/10/09	32	Чандмань-Оточ
9	Үхэр	Боом-Вакцин	2024/05/24 - 2024/05/24	24	Чандмань-Оточ
10	Үхэр	Галзуу-Вакцин	2024/08/26 - 2024/08/26	30	Чандмань-Оточ
11	Адуу	Бусад-Туулгалт	2024/08/27 - 2024/08/27	7	Чандмань-Оточ
12	Үхэр	Бруцеллөз-Вакцин	2024/10/20 - 2024/10/20	14	Чандмань-Оточ
13	Үхэр	Шүлхий-Вакцин	2024/11/23 - 2024/11/23	39	Чандмань-Оточ
Халдварт өвчний голомтгүй болон шимэгчтэх өвчний халдварт өртөөгүй эрүүл малтай өрх.					

Төлөвлөгөөт бус ажлын мэдээлэл

#	Өвчин	МЭҮ	Огноо	Малын эмч	Малын төрөл
Халдварт өвчний голомтгүй болон шимэгчтэх өвчний халдварт өртөөгүй эрүүл малтай өрх.					

Зураг





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 4/03

Баянтал сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Лүн багт байрлах 101, 102, 103, 104 дүгээр орон сууцуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

(Сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

(Засаг даргын Тамгын газрын дарга)

(Лүн багийн Засаг дарга)

(Хууль, Эрх зүйн мэргэжилтэн)

(Нийгмийн бодлого, худалдан авах

ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

(Аж ахуйн нярав)

(Лүн багийн иргэн)

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 4104

Баянтал сум

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон
зээлийн хүүгийн орлого зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, ХХААХҮСайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 2.7 дах заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 50 хүртэл хувийг хууль тогтоомжид нийцүүлэн захирамжийн хавсралтын дагуу зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хүүгийн орлого 1715000 (нэг сая долоон зуун арван таван мянга) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас зарцуулахыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д зөвшөөрсүгэй

3. Сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын хорооны дарга (Х.Мөнхбаатар)-т үүрэг болгосугай.



ДАРГА

Э.БАТТУЛГА

Сумын Засаг даргын 20-ны ... дугаар сарын
...ны өдрийн ... дугаар захирамжийн ...-р хавсралт



Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалт

№	Зардлын ангилал	Мөнгөн дүн
1	Сургалт сурталчилгаа	240000
2	Программ хангамж	610000
3	Төслийн үр дүн, хяналт шалгалт	343000
4	Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн урамшуулал	522000
	Нийт / төгрөг /	1715000



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/05

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66,1 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 43.2, 46.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол, сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ны А/ 04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1. "Шинэ хоршоо хөдөлгөөн" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн тайлан, мэдээ гаргах талаар мэдээлэл өгөх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажилд зориулж хөрөнгө гаргасугай.

2. Сургалтад зориулах 240000 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангаас гаргахыг нягтлан бодогч /Б.Солонгомаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын хорооны дарга (Х.Мөнхбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

БАТЛАВ.ЗАСАГ ДАРГА  Э.БАТТУЛГА

Хоршооны гишшүүдэд зориулсан сургалтын зардлын төсөв

2025.01.21

№	Нэр	Тоо	Нэгж.үнэ	Нийт дүн
1	Кофе	50	500	25000
2	Печень	51	500	25500
3	Ус	45	1100	49500
4	бууз	60	2000	120000
5	Сүүтэй цай	2	10000	20000
Нийт дүн				240000

Төсөв тооцсон: Мэргэжилтэн



С.Оюунтүлхүүр

Сумын Засаг даргын 2025 оны 01 дугаар
сарын 21-ны өдрийн А/8 тоот
захирамжийн 1-р хавсралт

СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Зорилго : “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа явуулж байсан хоршоодын гишүүдэд мэдээлэл өгөх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах , зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор сургалт зохион байгуулна.

Үйл ажиллагаа :

1. Татварын багц хуулийн шинэчлэлт /Хэлэлцүүлэг /
2. Малчид болон хоршоод орлогын албан татвар хэрхэн тайлагнах талаар сургалт, дадлага
3. Засгийн газраас малчдын талаар барьж буй бодлого, төлөвлөлт,
4. Хувь хүний хөгжлийн сургалт

Хамрах хүрээ, оролцогчид:

1. Татварын газар
2. Аймгийн ХХААГазар
3. Сумын ЗДТГ
4. Хоршоодын төлөөлөл малчид

Зохион байгуулагдах газар: Сургалтыг Баянтал сумын 2-р багийн нутаг “Оорцог-Элгэн хоршоо” -ны гэр ресторанд 2025 оны 01 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулна.

Үр дүн:

1. Татварын багц хуулийн шинэчлэлд саналаа оруулсан байна
2. Татварын хуулийн талаар мэдлэг олсон байна.
3. Орлогын албан татвараа тайлагнаж сурсан байна
4. Хувь хүний хувьд хөгжсөн байна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
“ СУРГАЛТ ”-ЫН ХӨТӨЛБӨР**

Нэг. Зорилго

Баянтал сумын малчин хоршоодын төлөөлөлд Татварын багц хууль, Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг танилцуулах, сурталчлах, цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах, хоршоогоор дамжин малчин, мал бүхий иргэд төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад энэхүү сургалтын зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөр

№	Зохион байгуулагдах үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
2025 оны 01 сарын 22-ны өдөр			
1	Сургалтад оролцогчдыг бүртгэх	10:00-10:30	ХААТ мэргэжилтэн
2	“Татварын багц хуулийн шинэчлэл” хэлэлцүүлэг	10:30-12:30	Аймгийн Татварын газрын дарга П.Энх-Оюун
3	Цайны завсарлага	12.30—12.40	
4	Малчид болон хоршоод орлргын албан татварын тухай хууль	12. 40-13:30	Аймгийн татварын газрын татвар төлөгчтэй харьцах тасгийн ахлах байцаагч Н.Мөнхмандах
5	Үдийн хоол	13.30-14.00	
6	Хувь хүний хөгжлийн сургалт	14:00-14:30	Засаг дарга Э.Баттулга
7	Малчид болон хоршоод орлргын албан татвар хэрхэн тайлагнах талаар дадлага	14.30-1500	Аймгийн татварын газрын татвар төлөгчтэй харьцах тасгийн улсын байцаагч А.Ариунгэрэл
8	Малчдын талаар МУЗГаас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр , ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар	15.00-16.30	Аймгийн ХХААГ

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 4/06

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2025 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хөрөнгөөр хийгдэх "Хүүхдийн олон төрөлтэй тоглоом авах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:

Ц.Булган (Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн)

Э.Энхсайхан (4-р Цэцэрлэгийн аж ахуйн нярав)

Д.Сувд-Эрдэнэ (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Булган)-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ө.БАТТУЛГА





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/07

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2025 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хөрөнгөөр хийгдэх "Гудамж, талбайн гэрэлтүүлгийг шинэчлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ц.Булган (Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

М.Амаржаргал (Талын Илч ОНӨААТҮГазрын ХАЭБ)

Д.Сувд-Эрдэнэ (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Булган)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 4/08

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2025 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хөрөнгөөр хийгдэх "Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийг хийх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:

Ц.Булган (Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн)

А.Батунгалаг (Талын Илч ОНӨААТҮГазрын нярав)

Д.Сувд-Эрдэнэ (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Булган)-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 4/09

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2025 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн хөрөнгөөр хийгдэх "Төрийн албан хаагчдын тоног төхөөрөмжийг сайжруулах, тавилга эд хогшил шинэчлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:

Ц.Булган (Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн)

М.Амаржаргал ((Талын Илч ОНӨААТҮГазрын ХАЭБ)

Д.Сувд-Эрдэнэ (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Булган)-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

